

“ҮЗЭСГЭЛЭНТ НҮДЭН ЧИМЭГ” СУДАРТ БУЙ АМЬТНЫ ГАРАЛТАЙ
ЭМИЙН ОНЦЛОГ, ТООГ ТОДРУУЛАХ НЬ

Г.Сумъяахорол¹, Б.Сумъяацэрэн², М.Шинэгэрэл³, Ш.Болд⁴

^{1,2,3}Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,

⁴Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

IDENTIFYING THE SPECIALTY AND NUMBER OF ANIMAL-ORIENTED
MEDICINES IN THE “MDZES MTSHAR MIG RGYAN” SUTRA

Sumyakhorol G¹, Sumyatseren B², Shinegerel M³, Bold Sh⁴

^{1,2,3}Mongolian University of Pharmaceutical Sciences

⁴Traditional Medical Research Institute

Email:sumiyakhorol1024@gmail.com

Abstract

Introduction: More than 30 years have passed since the revived and developed of traditional medicine, and dozens of textbooks and publications on traditional medicine have been published and qualified personnel have been trained. However, there is a need to drastically improve the quality of traditional medical care and the knowledge and skills of doctors. Therefore, it is important to translate, study books written by ancient physicians, maaramba, and scholars, and to apply theory, diagnosis, and treatment methods in training and practice.

Research materials and methods

Basic research materials: Naiman toin Jambaldorj (1792-1855). གསེས་བྱེད་མཛེས་མཚན་ མིག་རྩམ་། Tibetan scripture of a wooden printing block.

Method: We used hermeneutic method and checklist method.

Result: In the frame of this research, we used the medical sutra written by Jambaldorj as the main material in order to clarify the specialty and number of animal-oriented medicines in the “mdzes mtshar mig rgyan”. During the research, it was possible to clarify the structure, general content, and specialty of the sutra written by Jambaldorj, classify animal-oriented medicines according to the Cyrillic alphabet, and make allegory names for some of the raw materials of animal origin. In addition, the study of animal-oriented medicines in the sutra showed that many issues were important, such as their identification, usages, and new production. As a result of the first study, we identified the characteristics and usages of some essential animal-oriented medicines.

Conclusion: Jambaldorj began writing the “mdzes mtshar mig rgyan” before leaving for Tibet, and later, during his pilgrimage to Tibet, he enriched and completed it in his book. It was found to correspond to the period 1817-1823. A selection of 124 animal-oriented medicines from the book “mdzes mtshar mig rgyan” was made. In this way, it is possible to interpret and explain the hidden meanings of animal-oriented medicines in this sutra, and to determine the usages of pharmacology and drug formulations.

Key words: animal-oriented medicines, sutra, Jambaldorj and “mdzes mtshar mig rgyan”

Үндэслэл

Монголын уламжлалт анагаах ухаан 5000 гаруй жилийн түүхтэй бөгөөд манай ард түмний оюун ухаан, эрдэм мэдлэгийн үнэт өвүүдийн нэг билээ. Энэхүү өв бидний өвөг дээдсийн сэтгэлгээний цар, нөр их хөдөлмөрийн үр шимээр цогцлон бүрдэж, өнгөрсөн зуунуудын түүхэн шалгуурыг туулан өнөөг хүрч ирэхдээ хөгжин цэцэглэх, уруудан доройтох түмэн нугачааг даван туулж, тэжээх ухаан, монголчуудын эрүүл амьдрах ухааны бүхэл бүтэн тогтолцоог бий болгон хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсаар иржээ¹. Уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжөөд 30 гаруй жил өнгөрч, уламжлалт анагаах ухаан судлалын хүрээнд олон арван сурах бичиг, бүтээл гарч, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэгдэж байгаа хэдий ч уламжлалт эмнэлгийн тусламжийн чанар, эмч нарын мэдлэг, мэргэжлийг эрс дээшлүүлэх шаардлагатай байна. Үүний тулд хуучин цагийн эмч, маарамба, эрдэмтдийн бичсэн ном судрыг орчуулах, судлах, онол, оношилгоо, эмчилгээний аргуудыг сургалт, практикт хэрэглэх нь тулгамдсан асуудал болоод байна.

Зорилго: Тойн Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” эмийн судрын амьтны гаралтай түүхий эдийн зарим онцлог, нэрсийг тодруулах.

Судалгааны материал, арга

Судалгааны үндсэн материал: Найман тойн Жамбалдорж (1792-1855). གསོ་བྱེད་མཛེས་མཚར་མིག་རྩན། модон барын төвөд судар².

Судалгааны арга: Герменевтик арга нь тайлбарлах тодруулах гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд сэдвийн өгүүлэмж, зохиогч, нэр томьёо, үгийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулахад герменевтик арга зүйг боловсруулсан. Түүнчлэн судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг. Иймээс

энэхүү арга нь судалж буй асуудлын нэр томьёог үгийн гарал, үүсэл далд утга, давхар санаа, агуулгыг судлан тогтоох зэрэгт ашиглав. Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь сурвалж бичгийн доторх амьтны гаралтай эмийн түүхий эдийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэх арга юм.

Үр дүн: XXI зууны уламжлалт анагаах ухааны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтдийн бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судрыг уншиж судлах, уг номонд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамба нарын гарын авлага, увдисын гүн утгыг онож ойлгох нь нэн чухал байдаг. Үүнийг шийдвэрлэхэд чухал түлхэц өгөх судалгааны чиглэл нь уламжлалт анагаах ухааны эм судлалын эртний судрыг судлах, энэхүү судлалыг хөгжүүлэх асуудал юм. Бид энэхүү судалгааны хүрээнд амьтны гаралтай эмийн онцлог, тоог тодруулахдаа གསོ་བྱེད་བཟང་སློབ་འཁྲུལ་མཛེས་མཚར་བཟོ་རིག་མཁོང་ལྷ་རྩན་པར་ཤར་བ་མཛེས་མཚར་མིག་རྩན་ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།³ (Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт чимэг хэмээх оршвой), товчоор “Үзэсгэлэнт нүдэн чимэг, төвөдөөр товчлон མཛེས་མཚར་མིག་རྩན། (Зэйцар мигжан) гэж нэрлэдэг Найман тойн Жамбалдоржийн зохиосон судрыг үндсэн материал болгов. Одоогоор хоёр янзын “Үзэсгэлэнт нүдэн чимэг” олдоод байгаа бөгөөд хооронд нь ялгахын тулд их, бага хэмээн ялган үздэгээс энд дурдан буй их “Үзэсгэлэнт нүдэн чимэг”-ийн төгсгөлийн үгэнд: “Шар титэмтийн шашны өглөгийн эзэн, ухааныг баригч Наймны увш Жамбалдорж бээр бичив” хэмээсэн байдаг. Тэрбээр хорин таван настайдаа гэрээс магад гарах санаа машид их хүрсэн тул бурхан багш Шагжамүнийг даган дуурайж эд хөрөнгө, эрх хүч, хотол төгөлдөр байсан ч тэр бүхнийг эс огоорон Ханчин түмэд Агвааншаравын өлмийн дэргэд тэргүүний үсээ өргөж гэрээс

гарч тойн болж шар малгайтын шашны шавь, томоохон өглөгийн эзэн байжээ^{4,5}.

Судалгааны явцад тойн Жамбалдоржийн бичсэн эмийн судрын бүтэц, ерөнхий агуулга, ямар онцлогтойг тодруулан амьтны гаралтай эмийн түүхий эдийг кирилл үсгийн цагаан толгойн дагуу ангилж уг түүврээс амьтны гаралтай зарим эмийн түүхий эдийн илт өгүүлэх нэрийн тайлбар хийх боломжтой болов. Түүнчлэн уг сударт буй амьтны гаралтай эмийн түүхий эдийг судлахад юуны өмнө тэдгээрийг танин мэдэх, ашиглах, зохиомлоор гарган авах зэрэг олон асуудал чухал гэдэг нь харагдаж байв. Амьтан судлал нь олон сая жилийн түүхэн хөгжлийг дамжин ирэхдээ 1700-аад он гэхэд биологич Карл фон Линне нь төрөл бүрийн амьтад, түүнчлэн өөр ургамлуудыг ангилсан үр дүн, амьтдын талаар урьд өмнө үзэгдэж байсан бүх үзэгдлийн тухай ойлголтыг⁵ нэгтгэн Чарльз Дарвин 1859 онд “Зүйлийн гарал үүсэл” хэмээх номоо хэвлүүлж⁶, хувьслын онол, байгалийн шалгарлын явцыг тайлбарласан нь Монгол анагаах ухааны амьтны гаралтай түүхий эдийн онцлог, ангиллыг шинжлэх ухааны үндсийг тодруулахад чухал суурь болно. Бид эхний судалгааны үр дүнд зайлшгүй шаардлагатай зарим амьтны гаралтай эмийн онцлог шинж, хэрэглээг тодруулсан болно.

Амьтнаас гарсан эмийн зүйл нь: эвэр, яс, мах, цус, цөс, өөх, тархи, арьс, хумс, үс, шээс, сангас, бүхэл бие лүгээ арван гурав буй. Тэдгээрийн аль нь алинд туслах чадлыг үзүүлбэл. Бодь гөрөөсний эвэр бол хэнхдэг цээжний өгөр цус, шар усыг хатаах. Буга, гурын эвэр ч түүн лүгээ адил чадалтай. Оронго, зээрийн эвэр нь суулгахыг зогсоох. Бөхөн, хуцын эвэр нь илчийг үүсгэж, бэтгийг эвдэх. Аргалын эвэр нь хижиг өвчнийг арилгах. Хүний хуучин гавал шар усыг хатаах. Хүний хувхайрсан яс, дал үнсээр хуучирсан халуун

биед шунасныг ховхлох, хүний сүүжний яс боомыг нядлах. Луугийн яс нь илжирснийг тасалж, сорвийг эдгээх. Барын яс нь хэмийг ирүүлэх. Явууны үнс бол цусыг тогтоож, өгөр усыг хатаах. Аянганд эндсэн хүний яс гэдэсний хатгалгаар үхэгсдийн гавал нь гэдэсний хатгалга дарах. Гахайн яс бор, бадганыг арилгах. Хонины яс хий өвчнийг арилгах. Хонины тойг бол шээс хаагдсаныг гаргах. Зарааны яс цус алдахыг зогсоох. Бичний яс хөвгүүнийг гарган үйлдэх. Шанаган хорхой (бүжог) нь хорхойг арилгаж, усан хаванг туулгах болмой. Битүү туурайтны яс шар усыг арилгадаг юм. Хүний мах чихихаг арилган, хий, хор, нянг дарах. Могойн мах, цугласныг эвдэж, хаагдсаныг гарган, нүдэнд тустай. Тасын мах илчийг үүсгэн, ашгийг эвдэх. Тогосын мах шар, хорын өвчнийг арилгах. Цасан гүрвэлийн мах бөөр, бэлхүүсний хүйтнийг арилгах. Халиуны элэг, шээс боогдсоныг тавиулах. Тарваганы элэг хугарсан ясыг барилдуулах. Ямааны элэг нүдэнд маш тустай. Уушги, зүрх, элэг, дэлүү, бөөр нь өөр өөрийн өвчнийг арилгах. Чонын ходоод, илчийг үүсгэж, эс шингэснийг шингээх. Чонын хэл нь хэл хавдсаныг дарах. Гахайн хэлээр хэмхэрсан ясыг гаргах. Нохойн хэлээр шарх нугуудыг эдгээх. Илжигний хэлээр суулгахыг тогтоох. Хуцын им хүчжүүлэх, нохойн им умайд үхсэнийг гаргах, үнэг, хараацайн уушгиар уушги нэвчихийг зогсоох. Багваахайн мах бөөлжихийг зогсоох. Богширго (хидаруу), хадны гүрвэл бол дуслыг нэмэгдүүлэх. Ангирын мах булчин урвахыг арилгах болой. Бугын цус нь хорхойг арилган, умайн цусыг таслах. Ямааны цус бол хүрэлцсэн хор, хар бодоог арилгах. Бух гөрөөсний цус, оронгын цус уруу суулгахыг зогсоох. Гахайн цус нь хор, бор бадган тархсаныг хураах. Илжигний цус хэрэх, үесийн шар усыг арилгах. Тахианы өрөвлөг (цэцэг)-ийн цус махыг төлжүүлж хэмийг тогтоох. Умайн цус (сарын хир) бол цусны судлыг боох, махыг төлжүүлэх

болой. Цөсний зүйл бүгд судлын амыг боож, илжирснийг таслан, махыг гүйцээн төлжүүлж, хорыг арилган, нүдэнд тустай. Могойн өөх бол хоцорсон зэв сумыг гаргах. Бугын өөх хорхойг арилгаж, хор өвчнөөс хамгаалах. Гахайн өөх хорыг хураан, нясууг арилгах. Хүний өөх хийг даран нясууг арилгах болно. Ямааны тархи бүлх шөрмөс тасарсныг анагаах. Хонины тархи нь толгой эргэх, тархи унахыг анагаах. Гөрөөсний тархи суулгахыг зогсоох. Туулайн тархи гэдэс хатгалахыг арилгах. Хүний тархи хавдсаныг арилган, шар усыг эвдэх болно. Могойн арьс нь алаг мариа, нясуу арилгах. Бодь гөрөөс, зааны арьс нь хар бодоог арилгах. Хулганын арьс өгөрийг гаргах болно. Матрын хумс нь ясны халууныг арилгах. Илжигний туурай бол шээс хаагдсаныг арилгах. Морины туурай бэтэг өвчнийг арилгах. Морины хуланс (живэр) нь булчин урвахыг арилгах болой. Тогосын отго нь хор, уушгины өгөрийг арилгах. Хар галууны өд шээс хаагдахыг арилгах. Олби оготнын өд умайн өвчнийг арилгах. Угалзын үс нь хор өвчнийг арилгах. Ухнын хуухнагийн үс (шээг) бол боомыг дарах болой. Хүний шээс нь нян хорхойг арилгаж, хижгийг сэргийлэх. Үнээний шээс нь шар ус, хуучин халууныг туулгах юм. Хачир тасын сангас (баас) бол илчийг үүсгэн, бэтгийг эвдэх, хавдрыг хариулах. Гахайн сангас үл шингэх, нян хижиг шар, бэтэг арилгах. Хүний баас шар, бэтэг, хорыг арилган, хавдар хариулах. Морины баас бол хорхойг арилган, шар, хий, бөөлжихийг зогсоох. Туулайн хоргол усан хаванг туулгах. Нохой, чоно, хахилагийн сангас бол хавдрыг хариулах. Болжмор, хулганын сангас нь өгөрийг гаргах. Хөхөө шувууны сангас нь хавдрыг өгөр болгох болой. Шим хорхой (жанч хорхой) нь судлын өвчнүүдийг туулгах. Наймаалж усны хорхой хоёр шээс хаагдахыг арилгах. Цох хорхой, өмхий хорхой нь цанхыг арилгах. Балчирганын хорхой нь судлын цус гарахыг тогтоох. Хурын хорхой нь

тархи гарахыг тогтоох. Усан хулгана, хадны шувууны мах нь махны хорыг арилгах. Гүрвэл нь хорхой өвчин, хорын өвчнийг арилгана ^{7,8,9}.

Судалгааны өөр нэгэн үр дүн бол амьтны гаралтай түүхий эдийн нэрсийг тогтоон эрэмбэлэн жагсаасан. Манай улсын хувьд байгаль цаг агаар, газарзүйн олон янз нөхцөлтэй учир дэлхийн амьтны аймгийн олонх төлөөлөгчид нутаглан амьдрах нөхцөл нь бүрджээ. Монгол орны амьтны аймаг, нугаламт амьтдын зүйлийн хөхтөн 141, шувууд 502, загас 79, хоёр нутагтан 6, мөлхөгчид 22 зүйл буюу нийт 750 зүйл, нугаламгүйтэнээс зөөлөн биетэн 41, хорхой 86, үе хөлтөн 5128 амьтдын нийт 5255 зүйл бүртгэгдээд байна. Жамбалдоржийн дээр дурдсан зохиолд гарч буй эмийн нэрийг ажиглавал тухайн амьтны өнгө, хэлбэр дүрс, анагаах чадварт голлон өгдөг байжээ. Мөн Энэтхэг, Төвөдийн анагаах ухаантнуудын ном зохиолыг судалгааны ажилдаа өргөнөөр ашигласан байх ба амьтны эмийн үүссэн түүхийг домог зүйтэй холбон тайлбарласан байна. Эмийн нэрийг судлах нь анагаах ухааны сурвалж бичиг дэх эмийн нэр томъёог судлах, эмийн жорд гардаг эмийн нэрийг зөв таньж, зөв найруулахад практик ач холбогдолтой юм.

Амьтнаас гарсан эм

1. Аалз
2. Алаг бамбу
3. Алтан гургалдай
4. Ангир галуу
5. Аргаль
6. Арслан
7. Баавгай
8. Багбаахай
9. Балчирганы өт
10. Барс
11. Бодь гөрөөс
12. Бөвгэлжин
13. Бөхөнгийн эвэр

- | | |
|---------------------|---------------------------|
| 14. Буга | 56. Сарлаг |
| 15. Бух гөрөөс | 57. Сидира |
| 16. Бүргэд | 58. Солонго |
| 17. Бүрэгэ хорхой | 59. Тагтаа |
| 18. Бэсрэг хайнаг | 60. Тарагны өт |
| 19. Бялзуухай | 61. Тарвага |
| 20. Галидинга | 62. Тас |
| 21. Галуу | 63. Тахиа |
| 22. Гарьд | 64. Тогоруу |
| 23. Гахай | 65. Тогос |
| 24. Гоо бялзуухай | 66. Тоншуул |
| 25. Гур | 67. Тоть |
| 26. Гургуул | 68. Төмөр могой |
| 27. Гүрвэл | 69. Турлиах |
| 28. Гэрийн шувуу | 70. Туулай |
| 29. Давалгаан шувуу | 71. Тэмээ |
| 30. Ёл | 72. Улаан толгойт болжмор |
| 31. Заан | 73. Усан үхэр |
| 32. Загас | 74. Усан хулгана |
| 33. Зэрлэг гахай | 75. Ууль |
| 34. Зэрлэг үхэр | 76. Үнэг |
| 35. Зэрлэг хайнаг | 77. Үхэр |
| 36. Зэрлэг ямаа | 78. Үхэр цох |
| 37. Зээр | 79. Хадан гүрвэл |
| 38. Илжиг | 80. Хайнаг |
| 39. Ирвэс | 81. Халиу |
| 40. Лаг мэлхий | 82. Хануур хорхой |
| 41. Луу | 83. Хар галуу |
| 42. Луус | 84. Хар загас |
| 43. Мангис | 85. Хараацай |
| 44. Могой | 86. Харцгай |
| 45. Морин зөгий | 87. Хахилаг |
| 46. Морь | 88. Хилэнцэт хорхой |
| 47. Муур | 89. Хирсийн эвэр |
| 48. Мэлхий | 90. Хон хэрээ |
| 49. Наймаалж | 91. Хонь |
| 50. Наги | 92. Хөдөг |
| 51. Нохой | 93. Хөхөө |
| 52. Олби оготно | 94. Хулан |
| 53. Оронго | 95. Хулгана |
| 54. Өмхий цох | 96. Хулсан барс |
| 55. Самж | 97. Хүдэр |

